

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Иххэт сумын хүн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2024/117/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2024 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг:
oyuntulkhuur.u@audit.gov.mn
Ахлах аудитор/аудитор: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com
Интакс Эксперт Ди Си ХХК-ийн захирал: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучуул гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogoviy.audit.gov.mn

2024.02.23 № 1-6/160

танай _____-ны № _____-т

**ИХХЭТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Э.АЛТАНЦЭЦЭГ
ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Иххэт сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Иххэт сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Тайлант онд харьяа сумын иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлэхээр ЭМДЕГ-тай гэрээ байгуулан 558.6 сая төгрөгийн санхүүжилт авч тусламж үйлчилгээнд зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Үлдэх өртөггүй 6 нэр төрлийн үндсэн хөрөнгөнд бүртгэлийн хяналт тавьж үнэ, болон ашиглах жилийг шинэчлэн бүртгээгүй. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 6-р сарын 18 өдрийн Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7.1-ийг зөрчсөн.

010920019

Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай 1 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй байна.

2023 оны байдлаар иргэдээс үзүүлж байгаа төлбөрт үйлчилгээний орлогын цахим төлбөрийн систем дэх И-баримтын дүн санхүүгийн тайлангийн орлогын дүнгээс зөрүүтэй байна. Энэ нь ЭМС-ын 2022 оны А/216 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ын 3.4-т заасан "И-баримт" заавал олгоно гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Ебаримт- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 15 ширхэг 54,586 мянган төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 6 ширхэг 9,416 мянган төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан, баталгаажаагүй буцаалтын зөрчилтэй байлаа.

36600 тоот бусад нөөцийн бараа дансанд барилгын зураг төсөл гэсэн бараа бүртгэсэн байна. Энэ нь бараа материалын тооллогын тайланд байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоо олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т. ГАН-ӨЛЗИЙ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	278,435,003.71	305,314,273.23
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	132,069,463.57	143,773,390.67
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	132,069,463.57	143,773,390.67
31210	Төгрөг	132,069,463.57	143,773,390.67
31211	Төрийн сангийн харилцах	132,069,463.57	143,773,390.67
33	АВЛАГА	10,180,160.00	15,914,170.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	10,180,160.00	15,914,170.00
35	БАРАА МАТЕРИАЛ	132,685,380.14	142,126,712.56
35100	Түүхий эд материал	93,370,091.99	90,292,660.41
35110	Тусгай зориулалттай материал	36,455,717.67	37,570,714.73
35130	Эм боох материал	56,914,374.32	52,721,945.68
35400	Хангамжийн материал	39,315,288.15	51,834,052.15
35410	Бичиг хэргийн материал	6,103,076.00	6,996,662.00
35420	Аж ахуйн материал	22,944,600.00	29,577,100.00
35430	Сэлбэг хэрэгсэл	7,451,500.00	13,077,800.00
35440	Түлш, шатах тослох материал	0.65	0.65
35460	Хүнсний материал	2,816,111.50	2,182,489.50
36	НӨӨЦИЙН БАРАА	3,500,000.00	3,500,000.00
36600	Бусад нөөц	3,500,000.00	3,500,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	797,330,854.33	798,523,275.01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	797,330,854.33	798,523,275.01
39200	Биет хөрөнгө	789,983,854.33	791,607,525.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	726,248,349.00	726,248,349.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-54,478,951.89	-80,416,392.93
39203	Авто-тээврийн хэрэгсэл	65,000,000.00	65,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-26,972,916.87	-34,247,916.87
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	152,070,635.78	170,320,039.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	-90,961,522.30	-89,406,102.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,587,554.00	45,173,650.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,509,293.39	-14,804,101.10
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,679,600.00	3,740,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,679,600.00	0
39300	Биет бус хөрөнгө	7,347,000.00	6,915,750.00
39301	Програм хангамж	2,220,000.00	1,725,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,645,000.00	-1,581,250.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,772,000.00	6,772,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,075,765,858.04	1,103,837,548.24
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	335,541.12	4,958,980.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	335,541.12	4,958,980.00
41300	Өглөг	335,541.12	4,958,980.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	136,041.12	0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	199,500.00	4,182,080.00
41360	Бусад өглөг	0	776,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0	776,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,075,430,316.92	1,098,878,568.24
51	Засгийн газрын хувь оролцоо	1,075,430,316.92	1,098,878,568.24
51100	Засгийн газрын оруулсан капитал	270,785,493.00	0
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	270,785,493.00	0
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0	270,785,493.00
51200	Хуримтлагдсан үр дүн	474,792,396.86	498,240,648.18
51210	Өмнөх үеийн үр дүн	-564,786,740.71	474,792,396.86
51220	Тайлант үеийн үр дүн	1,039,579,137.57	23,448,251.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	329,852,427.06	329,852,427.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,075,765,858.04	1,103,837,548.24

4417144353
EICA0056 9025707

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	/ төгрөгөөр / ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,660,201,493.62	706,144,449.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,026,578,868.86	81,948,853.28
120	Нийтлэг татварын бус орлого	1,026,578,868.86	81,948,853.28
120009	Бусад орлого	70,000.00	45,778.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	825,216,445.50	60,736,824.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	201,292,423.36	21,166,250.78
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	633,622,624.76	624,195,596.23
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	2,605,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0	2,570,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	35,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	70,289,064.76	62,999,881.92
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	70,289,064.76	62,999,881.92
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	563,333,560.00	558,590,714.31
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	563,333,560.00	558,590,714.31
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	620,622,356.05	682,696,198.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	620,622,356.05	682,696,198.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	620,622,356.05	682,696,198.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	262,187,115.68	338,081,098.90
210101	Үндсэн цалин	177,881,469.68	238,383,261.05
210102	Нэмэгдэл	63,710,793.00	78,594,659.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,606,000.00	3,700,000.00
210104	Урамшуулал	16,988,853.00	17,403,178.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,591,154.22	43,509,282.51
210201	Тэтгэврийн даатгал	22,599,743.54	30,226,912.20
210202	Тэтгэмжийн даатгал	2,607,855.75	3,376,893.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,086,284.55	2,761,236.35
210204	Ажилгүйдлийн даатгал	481,569.70	649,567.37
210205	Эрүүл мэндийн даатгал	4,815,700.68	6,494,673.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,064,194.76	57,999,881.92
210301	Гэрэл, цахилгаан	2,319,935.76	3,193,894.92
210302	Түлш, халаалт	51,977,400.00	52,067,400.00
210303	Цэвэр, бохир ус	2,766,859.00	2,738,587.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,409,583.40	47,819,694.00
210401	Бичиг хэрэг	4,777,840.00	2,893,814.00
210402	Тээвэр, шатахуун	34,964,360.00	28,184,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,485,000.00	2,020,000.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,382,800.00	3,542,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,834,600.00	11,178,800.00
210408	Бараа материал акталсны зардал	13,964,983.40	0
2105	Нормативт зардал	135,058,539.82	89,228,640.04
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	124,650,491.82	78,748,183.04
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,195,470.00	0
210604	Урсгал засвар	2,195,470.00	0
2107	Томилолт, зочны зардал	4,812,000.00	5,652,000.00
210702	Дотоод албан томилолт	4,812,000.00	5,652,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,851,197.00	33,121,197.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	779,500.00	32,197,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	810,000.00	648,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,925.00	200,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	10,000.00	13,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	6,772.00	6,772.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,453,101.17	67,284,403.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,150,000.00	2,255,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57,303,101.17	65,029,403.82
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,039,579,137.57	23,448,251.32
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,039,579,137.57	23,448,251.32

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	689,254,346.11	618,496,586.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,484,281.35	0
120	Нийтлэг татварын бус орлого	3,484,281.35	0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,484,281.35	0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	0
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	3,414,281.35	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	685,770,064.76	618,496,586.23
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	2,605,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0	2,570,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	35,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	70,289,064.76	62,999,881.92
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	70,289,064.76	62,999,881.92
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	615,481,000.00	552,891,704.31
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	615,481,000.00	552,891,704.31
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	527,767,372.54	601,307,659.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	527,767,372.54	601,307,659.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	527,767,372.54	601,307,659.13

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	282,417,718.06	338,195,155.82
210101	Үндсэн цалин	180,112,313.00	229,231,036.55
210102	Нэмэгдэл	81,710,552.06	88,393,740.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,606,000.00	3,567,200.00
210104	Урамшуулал	16,988,853.00	17,003,178.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,107,259.72	43,373,241.39
210201	Тэтгэврийн даатгал	22,831,504.57	30,090,871.08
210202	Тэтгэмжийн даатгал	2,422,712.81	3,376,893.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,938,170.21	2,761,236.35
210204	Ажилгүйдлийн даатгал	446,806.21	649,567.37
210205	Эрүүл мэндийн даатгал	4,468,065.92	6,494,673.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,064,194.76	57,999,881.92
210301	Гэрэл, цахилгаан	2,319,935.76	3,193,894.92
210302	Түлш, халаалт	51,977,400.00	52,067,400.00
210303	Цэвэр, бохир ус	2,766,859.00	2,738,587.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,296,590.00	47,086,730.00
210401	Бичиг хэрэг	6,756,610.00	3,579,550.00
210402	Тээвэр, шатахуун	32,943,980.00	26,961,580.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,385,000.00	1,920,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	2,023,200.00	3,625,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,187,800.00	11,000,300.00
2105	Нормативт зардал	77,347,573.00	56,569,621.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,472,023.00	45,781,421.00
210502	Хоол, хүнс	10,095,550.00	8,808,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,780,000.00	1,980,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,485,870.00	9,358,800.00
210604	Урсгал засвар	14,485,870.00	9,358,800.00
2107	Томилолт, зочны зардал	4,812,000.00	5,652,000.00
210702	Дотоод албан томилолт	4,812,000.00	5,652,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,851,197.00	33,121,197.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	779,500.00	32,345,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	810,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,925.00	200,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	10,000.00	13,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	6,772.00	6,772.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,384,970.00	9,951,032.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,384,970.00	9,951,032.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	161,486,973.57	17,188,927.10
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	29,417,510.00	5,485,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,417,510.00	5,485,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,417,510.00	5,485,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,417,510.00	5,485,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-29,417,510.00	-5,485,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	132,069,463.57	11,703,927.10
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	132,069,463.57
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	132,069,463.57	143,773,390.67

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	0	0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	270,785,493.00	329,852,427.06	-564,786,740.71	35,851,179.35
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	270,785,493.00	329,852,427.06	-564,786,740.71	35,851,179.35
9	Тайлант үеийн үр дүн	0	0	1,039,579,137.57	1,039,579,137.57
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	270,785,493.00	329,852,427.06	474,792,396.86	1,075,430,316.92
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	270,785,493.00	329,852,427.06	474,792,396.86	1,075,430,316.92
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	270,785,493.00	329,852,427.06	474,792,396.86	1,075,430,316.92
19	Тайлант үеийн үр дүн	0	0	23,448,251.32	23,448,251.32
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	270,785,493.00	329,852,427.06	498,240,648.18	1,098,878,588.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	742,783,400.00	543,792,777.21	198,990,622.79	73%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	742,783,400.00	543,792,777.21	198,990,622.79	73%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	742,783,400.00	543,792,777.21	198,990,622.79	73%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	469,149,900.00	338,195,155.82	130,954,744.18	72%
210101	Үндсэн цалин	279,003,100.00	229,231,036.55	49,772,063.45	82%
210102	Нэмэгдэл	133,052,400.00	88,393,740.90	44,658,659.10	66%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,249,700.00	3,567,200.00	1,682,500.00	68%
210104	Урамшуулал	51,844,700.00	17,003,178.37	34,841,521.63	33%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,195,300.00	43,373,241.39	16,822,058.61	72%
210201	Тэтгэврийн даатгал	39,912,400.00	30,090,871.08	9,821,528.92	75%
210202	Тэтгэмжийн даатгал	5,070,000.00	3,376,893.19	1,693,106.81	67%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,056,600.00	2,761,236.35	1,295,363.65	68%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,014,500.00	649,567.37	364,932.63	64%
210205	Эрүүл мэндийн даатгал	10,141,800.00	6,494,673.40	3,647,126.60	64%
2104	Хангамж, бараа материалын зардал	49,092,500.00	47,086,730.00	2,005,770.00	96%
210401	Бичиг хэрэг	4,870,700.00	3,579,550.00	1,291,150.00	73%
210402	Тээвэр, шатахуун	27,676,200.00	26,961,580.00	714,620.00	97%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,920,000.00	1,920,000.00	0.00	100%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,625,300.00	3,625,300.00	0.00	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,000,300.00	11,000,300.00	0.00	100%
2105	Нормативт зардал	99,782,000.00	56,569,621.00	43,212,379.00	57%

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	86,775,300.00	45,781,421.00	40,993,879.00	53%
210502	Хоол, хүнс	11,026,700.00	8,808,200.00	2,218,500.00	80%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,980,000.00	1,980,000.00	0.00	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,368,600.00	9,843,800.00	-1,475,200.00	118%
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,744,900.00	3,745,000.00	-100.00	100%
210602	Тавилга	1,740,000.00	1,740,000.00	0.00	100%
210604	Урсгал засвар	2,883,700.00	4,358,800.00	-1,475,100.00	151%
2107	Томилолт, зочны зардал	6,936,000.00	5,652,000.00	1,284,000.00	81%
210702	Дотоод албан томилолт	6,936,000.00	5,652,000.00	1,284,000.00	81%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,485,400.00	33,121,197.00	4,364,203.00	88%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,610,000.00	32,345,500.00	4,264,500.00	88%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	0.00	100%
210803	Даатгалын үйлчилгээ	201,000.00	200,925.00	75.00	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,400.00	13,000.00	86,400.00	13%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00	0.00	100%
210807	Газрын төлбөр	20,000.00	6,772.00	13,228.00	34%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,773,700.00	9,951,032.00	1,822,668.00	85%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,773,700.00	9,951,032.00	1,822,668.00	85%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	742,783,400.00	552,891,704.31	189,891,695.69	74%
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	610,713,900.00	552,891,704.31	57,822,195.69	91%
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	610,713,900.00	552,891,704.31	57,822,195.69	91%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	132,069,500.00	0	132069500	0%
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	132,069,500.00	0	132069500	0%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	134,674,463.57	134,674,463.57	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	143,773,390.67	143,773,390.67	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 160.8 мянган төгрөгийн 2 алдаа¹илэрснээс аудитын явцад 160.8 мянган төгрөгийн алдааг залруулсан

Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдлын тайлангаарх мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл банкны үлдэгдлийн баталгаанаас зөрүүтэй байв.
- Өглөгийн дансаар дамжуулж аккруэль сууриар бүртгэлийг хөтлөөгүй зардлын гүйлгээг залруулав.

Аудитаар нийт 16,415,4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 16,415.4 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар илрүүлсэн 16,415,4 мянган төгрөгийн 12,915.4 мянган төгрөгийн зөрчил нь хуулийн хэрэгжилттэй байх тул мөнгөн дүнг зөрчлөөс хасан тооцоход санхүүгийн тайлангийн зөрчил нь 3500.0 төгрөг болсон нь бидний тогтоосон материаллаг байдлаас бага байх тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө

5.1 Төлбөрийн акт

Аудитын илрүүлэлтэд төлбөрийн акт тавигдаагүй болно.

5.2 Албан шаардлага

Аудитын илрүүлэлтэд албан шаардлага өгөгдөөгүй болно

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт 1:

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээр анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 6 нэр төрлийн үндсэн хөрөнгөнд бүртгэлийн хяналт тавьж үнэ, болон ашиглах жилийг шинэчлэн бүртгээгүй.

Энэ нь үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Зөвлөмж

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 6 р сарын 18 өдрийн Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7.1-д заасныг хэрэгжүүлж ажиллах.

Илрүүлэлт 2:

Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай 1 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй байна. Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, дагуу мэдээллийг уг хуулийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэдэг хуулийн шаардлагын биелүүлж ажиллах.

Илрүүлэлт 3:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

2023 оны байдлаар иргэдээс үзүүлж байгаа төлбөрт үйлчилгээний орлогын цахим төлбөрийн систем дэх И-баримтын дүн санхүүгийн тайлангийн орлогын дүнгээс зөрүүтэй байна. Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна

Зөвлөмж

ЭМС-ын 2022 оны А/216 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ын 3.4-т заасан "И-баримт" заавал олгоно гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Илрүүлэлт 4:

Еbагimт- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 15 ширхэг 54,586 мянган төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 6 ширхэг 9,416 мянган төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан, баталгаажаагүй буцаалтын зөрчилтэй байлаа. Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна

Зөвлөмж

НББ-ийн тухай хуулийн 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон... бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэдэг хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Илрүүлэлт 5:

36600 тоот бусад нөөцийн бараа дансанд барилгын зураг төсөл гэсэн бараа бүртгэсэн байна. Энэ нь бараа материалын тооллогын тайланд байхгүй байна. Энэ нь оршин байх, тохиолдсон байх, үнэн зөв байдал гэх мэт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Зөвлөмж

Хөрөнгийн болон бараа материалын тооллогыг үр дүнтэй зохион байгуулж тооллогоор байхгүй бараа материал, үндсэн хөрөнгийг холбогдох тушаал шийдвэрийг үндэслэн данснаас хасах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 20 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайлангаарх мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл банкны үлдэгдлийн баталгаанаас зөрүүтэй байв.	1	45.778			1	45.778	1	45.78		
Өглөгийн дансаар дамжуулж аккруэл сууриар бүртгэлийг хөтлөөгүй зардлын гүйлгээг залруулав.	1	115			1	115	1	115		
ДҮН	2	160.78	-	-	2	160.78	2	160.8	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
36600 тоот бусад нөөцийн бараа дансанд барилгын зураг төсөл гэсэн бараа бүртгэсэн байна. Энэ нь бараа материалын тооллогын тайланд байхгүй байна.	1	3,500.0					1	3,500.0		
Үлдэх өртөггүй 6 нэр төрлийн үндсэн хөрөнгөнд бүртгэлийн хяналт тавьж үнэ, болон ашиглах жилийг шинэчлэн бүртгээгүй.	1						1			
ДҮН	2	3,500.0	-	-	-	-	2	3,500.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай 1 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй байна.	1	3,498.5					1	3,498.50
ДҮН	1	3,498.5					1	3,498.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
2023 оны байдлаар иргэдээс үзүүлж байгаа төлбөрт үйлчилгээний орлогын цахим төлбөрийн систем дэх И-баримтын дүн санхүүгийн тайлангийн орлогын дүнгээс зөрүүтэй байна. Энэ нь ЭМС-ын 2022 оны А/216 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ын 3.4-т заасан "И-баримт" заавал олгоно гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	0					1	-
Ебаримт-ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 15 ширхэг 54,586 мянган төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 6 ширхэг 9,416 мянган төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан, баталгаажаагүй буцаалтын зөрчилтэй байлаа.	1	9,416.9					1	9,416.90
ДҮН	2	9,416.9	-	-	-	-	2	9,416.90